



**“БОГД БАНК ХК-ЫН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН ЭРДЭНЭ ОВОГТОЙ БЯМБАЖАВЫН 2023 ОНЫ СҮҮЛИЙН ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН”**

## НЭГ. ТУЗ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 1.1 Миний бие банкны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр хоёрдох жилд ажиллаж, Богд банкны ажлын зохих мэдлэг, мэдээлэлтэй болж, ТУЗ-ийн гишүүний үүргээ зохих түвшинд хэрэгжүүлэх эрмэлзэлтэй ажиллаж байна.
- 1.2 ТУЗ-ийн цахимаар болон танхимаар хуралдсан 87 удаагийн төлөвлөгөөт болон ээлжит бус хуралд оролцож, нийт 145 асуудлаар санал, үндэслэгээ хэлж, хурлын шийдвэрт болон ТУЗ, хороодын хурлын тэмдэглэлд товч тусган ажилласан. Хурлаар хэлэлцсэн асуудлаар 200 гаруй санал дэвшүүлж, хурлын шийдвэрийн төсөлд өөрлөлт оруулах, үндэслэл эрхзүйн болон эдийн засаг, санхүү мөнгөн гүйлгээ, тооцооллыг чамбай болгох талаар ажилласан. ТУЗ-ийн дарга, гишүүд миний саналыг хүлээн авч, шийдвэрт тусгадагт болон надад хүндэтгэлтэй ханддагт би баярлаж явдаг.
- 1.3 Урьдын адил банк өдөр тутам шуурхай шийдэл зохих, тэхдээ ТУЗ-ийн шийдвэр шаардсан асуудлууд олон байснаас ТУЗ болон хороодын хурлыг ээлжийн бусаар цаг хугацаа алдахгүй хийх ажил энэ онд урдаас олон гарав. Зарим сард 13 удаа, 12-р сард 15 удаа хуралдсан. Энэ нь ажлын ачаалал ихийн хамт банкны ажил, үйлчилгээ улам өсөж, харилцагчдын сонирхолд нийцэн банк өсөж хөгжиж , ажилд нь сайжирч байгаагийн илрэл нь гэж үзнэ .
- 1.4 Зээлийн олголт, төлөлттэй холбогдсон олон асуудлаар ТУЗ-ийн шийдвэр шаардлагатай нь ТУЗ-ийг олон удаа бас богино хугацаанд хуралдуулах, хэлэлцсэн асуудлаар тайлбар, тодруулга гаргуулах, үндэслэл, тооцооллыг нягт нямбай, ил тод, бодитойгоор гүйцэтгэхэд онцлон анхаарч ТУЗ, хорооны шийдвэр гаргахыг шаардаж байсан.
- 1.5 Банкны 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан бизнес төлөвлөгөө, эрсдэлийн аппетит, мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбогдсон хууль, журмын заалтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн ажлууд, НҮБ-аас гаргасан банкны үйл ажиллагаатай холбогдсон конвенц, тогтоолууд, FATF-ийн зөвлөмжүүд, Волфсберг группээс гаргасан зарчмууд зэргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн ажлуудад нэлээд их хүч хөдөлмөр, хугацаа зарцуулсан.
- 1.6 Зээл олгох, төлүүлэх асуудал банкны бүх шатны удирдлага, ажилтнуудыг байнгын анхааралд байж, ялангуяа хугацаа хэтэрч болзошгүй, эсвэл төлөх хугацаа болсон зээл, эсвэл зээлийг төлөх эх үүсвэр хомс, олох орлого, ашигт нь бэрхшээл учирсан зээлдэгчийн зээлийг олон арга хэлбэрээр банк болон зээлдэгчдэд аль болох хохиролгүйгээр төлүүлэхэд баагүй анхаарч байна. Юуны урьд зээлдэгч өөрт нь байгаа эх үүсвэрийг нь материаллаг болон материаллаг бус байсан ч ашиглах арга боломж зээлдэгчдэд олгож, тус дэм болох, гэхдээ зээл , хүүгээ төлүүлэх зарчим баримтлан ТУЗ-ийн үйл ажиллагаанд ололцож, банкны нийт удирдлага банкны үйлчилгээгээ сайжруулахыг чухалчлан ажилласныг тэмдэглэж байна.

ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд Монголын банкуудтай хамтран ажиллах сонирхолтой(Богд банк) гадаадын зарим байгууллагын төлөөлөл уулзаж ярилцах хүсэлт гаргаж, “Засаглал, өмчлөх эрх, банкны эрсдэл, Монголын санхүүгийн зах зээл, байр суурь, өрсөлдөөн, банкны нөхцөл, Богд банкны ирээдүй зэргийн талаар тэдэнтэй чөлөөт ярилцлага хийсэн. Банкны ТУЗ-ийн дарга,



гүйцэтгэх захирал нар банкны гадаад хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, боломжит эх үүсвэр татахад ихээхэн анхаарсан нь банкны ажил, үр дүнд эергээр нөлөөлж байгаа болно.

- 1.1 Хараат бус гишүүний хувьд ТУЗ-ийн бүх хороодод дарга, эсвэл гишүүнээр ажилладаг, бас сонирхлын зөрчилтэй асуудлыг ТУЗ, хороодын хурлаар хэлэлцэхэд голлох үүргийг гүйцэтгэдэг, төслийг боловсруулдаг, бас дээр бичсэнээр ТУЗ, хороод нь ажлын шаардлагаар ээлжит бүс хурал олон удаа хийдэг зэрэгтэй холбогдож ТУЗ-ийн гишүүд, ялангуяа хараат бус гишүүд нэлээд шахуу ажилтай, цаг хугацаа алдахгүй байх, харилцагчдыг сайн судлах зэрэг онцлог банкны ажилд байдаг юм байна.
- 1.2 Банк нь харилцагчийн эрсдэл, газарзүйн байршил, улс орны эрсдэл, бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэх эрсдэл зэргийг сайтар судлан харилцагч тус бүрийн эрсдэлийг үнэлж ажиллах, урьд хийсэн үнэлгээгээ шинэчлэх арга хэмжээ авахыг гүйцэтгэх удирдлагад даатгахын хамт ТУЗ, хороо уг асуудлыг байнгын анхааралдаа байлгадаг.
- 1.3 ТУЗ, хороодын ажлыг улам сайжруулах, банкны гүйцэтгэх удирдлага, газар, хэлтэс, нэгжтэй ажиллах ажиллагаа, ТУЗ-аас тавих ажлын шаардлагыг нэмэгдүүлэх, ТУЗ, хороодын хурлаар хэлэлцүүлэх асуудлын боловсруулалтын эдийн засаг, хууль эрхзүй, утга агуулгын үндэслэлийг улам сайжруулах, ТУЗ-ийн гишүүдийг мэдээлэл, материалаар хангах, тэдний оролцоог жигд, идэвхитэй болгох зэрэгт ТУЗ-ийн өдөр тутмын ажлыг шуурхай, ил тод, тодорхой болгох зорилгоор ТУЗ-ийн ажлын албыг ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар ахлуулан банкны бүтцэд бие даалган байгуулсан. Одоогийн байдлаар энэ албаны ажил жигдрээгүй, ТУЗ, Хороодын хурлаар хэлэлцэх асуудлын боловсруулалт үндэслэлийг сайжруулах цаг хугацаанд нь мэдээлэл, материалыг танилцуулж байхад ТУЗ-ийн ажлын албанаас зохион байгуулах, шаардах талаар зохих ахиц гаргаасай гэсэн хүлээлттэй байна гэж би хувьдаа боддог.
- 1.4 ТУЗ, хороод нь банкны бүхий л асуудлаар зохих шийдвэр гаргаж байсны дотор үйл ажиллагаа жил, хагас жилийн үр дүн, тайлан, бизнес төлөвлөгөө, эрсдэлийн аппетит, тогтвортжуулалтын төлөвлөгөө, банкны бүтэц, ногдол ашиг хуваах, хөндлөнгийн аудит сонгох, тайланг нь хэлэлцэх, сонирхлын зөрчилтэй зээл, хэлцлийг шийдэх, энэ талаарх журмыг улам сайжруулах, гүйцэтгэх удирдлага, гүйцэтгэх захирлын жил, хагас жилийн ажлыг дүгнэх, банкны үйл ажиллагааны зохистой харьцааны үзүүлэлтийн биелэлт, явц зэрэг чухал асуудлыг шийдэхийн хамт зээл олгох, төлүүлэхтэй холбогдсон шуурхай шийдэх асуудлуудыг цаг алдахгүй хугацаанд нь шийдэж, харилцагчдад шуурхай үйлчилж, банкныхаа үр дүнг нэмэгдүүлэхэд ихээхэн анхаарсан гэж үзнэ.

## ХОЁР. ТУЗ-ИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХОРОО

- 2.1 Би уг хорооны даргаар ажиллаж, банкны чанарын гол үзүүлэлтэд анхаарсан.
- 2.2 Хорооны хурлыг танхимаар 5 удаа, цахимаар 2 удаа хийж, Банкны 2023 оны тогтвортжуулалтын төлөвлөгөө, эрсдэлийн аппетит, чанаргүй активыг бууруулах, мөнгө угаах, терроризмыг болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны тайлан, Монгол банкны ерөнхийлөгчийн тушаалаар өгсөн үүргийн биелэлт зэрэг нийт 12 асуудал хэлэлцэж, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулан санал нэгтэйгээр ТУЗ-д оруулж шийдвэрлүүлсэн. Хорооны ажилд гишүүд, банкны гүйцэтгэх удирдлага, багийн гишүүд идэвхтэй оролцож, банкны ажлаа гэсэн нэгдмэл зорилготой ажилласан.
- 2.3 Сонирхлын зөрчилтэй хэлцлийг зөвшөөрөх, батлах, банкийг төлөөлж гэрээ байгуулахтай холбогдсон журмыг өөрчлөн гүйцэтгэх захиралд банкны дэд захирал



зэрэг удирдах ажилтнуудад ТУЗ-аас баталсан дээд лимитийн хэмжээнд зээл олгохэрхийг олгох санал, төсөл ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн шийдсэн. Цаашид уг журмыг уlam нарийвчлан хуульд бүрэн нийцэж байх, шуурхай шударга, ижил нөхцөлтэй байх чиглэлээр боловсруулахаар ажиллаж байна. Цаашдаа сонирхлын зөрчилтэй зээлдэгчдэд олгох зээлийг тэдгээр зээлийг нэр төрөл, зориулалт бүрээр тогтоосон журмаар аль болох ил тод, шударга, гэхдээ банканд үр дүнтэй ажилласан хугацааг нь харгалзан урамшуулахад чиглэсэн журам тогтоох нь зүйтэй гэж үзнэ.

- 2.4 Эрсдэлийн аппетит, татварлуулах төлөвлөгөө, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, дотоод хяналтын хөтөлбөр, банкны эрсдэлийн чанарын үзүүлэлтүүдийн явц, биелэлт зэрэг асуудлыг Хорооны хурлаар нэлээд дэлгэрэнгүйгээр өргөтгөсөн байдлаар банкны удирдлагын багийн гишүүдийн оролцоотой хэлэлцэж байсан. Энэ нь банкны гүйцэтгэх ажилтнуудын хариуцлагыг дээшлүүлэх, мэдлэгийг нь өндөржүүлэхэд чиглэж байсан.
- 2.5 Тусгай хяналтыг зааврын дагуу гүйцэтгэж, ялангуяа сэжигтэй гүйлгээ нэг бүрийг хянаж хугацаа алдахгүй арга хэмжээ авах, өндөр дүнтэй(10 сая төг-өөс дээш) гүйлгээнд бодит хяналтыг гүйцэтгэж, тайлагнаж ажиллах үүрэг гүйцэтгэх удирдлагад өгч ажилладаг.
- 2.6 Эрсдэлийн аппетит, чанаргүй активын бууралт, өөрийн хөрөнгийн өгөөж, активын өгөөж, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, хөдөлмөрийн бүтээмж, зээл болон нийт активын харьцаа зэрэг үзүүлэлтүүдийн үндэслэлийг тухай бүр тооцож, бодит биелэх нөхцөлийг хангах, урьд оны тайлан, дүнгээр гарсан хувь хэмжээнээс бууруулахгүй байх, нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авч ажиллах нь банкны гүйцэтгэх удирдлагын чухал үүрэг мөн.
- 2.7 Богд банкны "Хөрвөх чадварыг үнэлэх дотоодын үнэлгээний тайлан"-г хянаж гишүүд олон талаас нь тодруулж нэмэлт оруулж ажилласан. ТУЗ-д тайланг танилцуулан шийдвэрлүүлсэн.

## ГУРАВ. АУДИТЫН ХОРООНЫ АЖИЛ

- 3.1 Аудитын хорооны даргаар ажиллахдаа банкны ДАГ-ын үйл ажиллагааг уlam сайжруулах, тэднийг түшиглэн хяналтын үр дүнг дээшлүүлэх, хараат бус хөндлөнгийн хяналтын мөрөөр тодорхой арга хэмжээ авахыг эрмэлзэж ажилласан.
- 3.2 Хорооны хурлыг танхимаар болон цахимаар 4 удаа хийж, 10 гаруй асуудлаар санал төсөл боловсруулан тал бүрээс нь хэлэлцэн төслөө ТУЗ-д оруулан шийдвэрлүүлсэн. ДАГ-ын дотоодын хяналтын 2022 оны дүнг хэлэлцэх үндсэн дээр уг газрын 2023 оны хяналтын төлөвлөгөөг батлан гүйцэтгэлийг хянаж ажилласан.
- 3.3 Хорооны хурлаар "Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд чиглэсэн дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр"-т аудитын хяналт хийх төлөвлөгөөг хэлэлцэж баталсан. Төлөвлөгөөний дагуу хийсэн аудитын дүнг оны эцсээр хэлэлцэж, энэ асуудлын хүрээнд Богд банкны ажил ямар хэмжээнд байгааг дүгнэж цаашдын чиглэлээ тодорхойлон ДАГ-ын 2024 оны төлөвлөгөөнд тусган ажиллах зорилт тавьж байна.
- 3.4 Хорооны өргөтгөсөн хурлаар "Хөндлөнгийн аудитын зөвлөмжийн дагуу Богд банкнаас зохион байгуулж байгаа ажлын гүйцэтгэл, явцын талаар банкны холбогдох газар, хэлтэс, ДАГ, гүйцэтгэх удирдлагыг орлуулан хэлэлцсэн. Богд банк нь сүүлийн 4 жил дараалан олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн 4 дэх том аудитын компани болох Эрнэст энд Янг Монгол компаниар санхүүгийн тайландаа аудит хийлгэж байгаа ба тэдний



дүгнэлт, зөвлөмжийг Богд банк хүлээн авч зохиож буй ажлын ололт, доголдол, тэдгээрийн давтамж зэрэг асуудлыг банкны санхүү хариуцсан дэд захирлаар илтгэл тавиулан нэлээд дэлгэрэнгүй хэлэлцсэн. Аудитын хорооны зүгээс энэ талаар банкны ажилд нэлээд шүүмжтэй хандаж, банкны бүх газар, хэлтэс, алба, салбарт энэхүү аудитын дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр зохиож буй ажлыг улам сайжруулах шаардлагатай гэдгийг анхааруулсан.

**3.5** Хөндлөнгийн хараат бус аудитаас 2022 онд өгсөн зөвлөмжийг 10 нь урьд 2021 онд өгсөн зөвлөмжид заасан доголдлыг давтсан гэдгийг цохон заасан.

Жишээ нь:

- Олон улсын 5-6 стандарт бүрэн мөрдөгдөхгүй байгаа, эдгээр нь эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зөв дохио санамж өгөн дүгнэлт гаргахад нэн чухал гэдгийг заасан.
- Хөрөнгийг анхнаас нь зөв оновчтой ангилж бүртгэдэггүй.
- Хөрөнгийг ерөнхий дэвтэрт ангилан бүртгэж, түүгээр хянадаггүй
- Барьцаа хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг хянах бүртгэл хангалтгүй
- Чанаргүйдлийн бүртгэл зөрүүтэй, зээлийн мэдээллүүд, хугацаа хэтрэлтийн тайлан зөрүүтэй
- Түрээсийн тооцооллыг шинэчилдэггүй, ерөнхий дэвтэрт бичдэггүй
- Орлогын албан татварын тооцоолол зөрүүтэй
- Сегментийн тайлан гардаггүй
- Зээл олголтын баримт дутуу, хуульчийн дүгнэлтгүй, эрсдэлийг дүгнээгүй зээл олгосон.

**3.6** Банкны газар, хэлтэс, алба, ялангуяа орон нутгийн салбарт аудитын дүгнэлт, зөвлөмж ажлын материал болж очдоггүй, аудитын ихэнх материал англи хэл дээр учраас тэд ашиглах, ажил болгох боломжгүй. Эрнест Янг Монгол компани нь Монгол улсын хуулийн этгээд атлаа аудитын материалыг монголоор хийдэггүй, Монгол хэлээр бичүүлэхэд нэмэлт төлбөр шаарддаг байдлыг зогсоо шаардлага байгаа талаар Аудитын хороо шүүмжтэй хандсан Хорооны гишүүд банкны зүгээс ихээхэн хөрөнгө зарцуулан өндөр мэргэжлийн хүмүүсээр хийлгэж буй аудитын дүгнэлт, зөвлөмжийг банкны ажилд тусган хэрэгжүүлэх талаар банкны гүйцэтгэх удирдлагаас зохиож буй ажлыг эрс сайжруулах шаардлагатай байгааг анхааруулсан болно.

**3.7** Дотоод аудитын газрын Аудитын төлөвлөгөөний улирал, жилийн биелэлтийг хянаж, хяналтын мөрөөр банкны газар, хэлтсээс зохиох ажлаа улам эрчимжүүлэхийг үүрэг болгосон. Дотоод аудитын газар нь хөндлөнгийн аудитын дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар зохиож буй ажил, явц, биелэлттэй танилцаж, ТУЗ, АХ-д мэдээлэл өгч ажилладаг байх журам тогтоохор хэлэлцэж, ТУЗ-ийн шийдвэр гаргуулахаар тогтсон.

**3.8** Богд банкны эхний хагас жилийн санхүүгийн тайланг Хорооны хурлаар хэлэлцэж төлөвлөсөн хэмжээнд болон орлого, ашгийн төлөвлөгөөг давуулан биелүүлснийг тэмдэглэсэн. Жилийн урьдчилан гүйцэтгэлтэй танилцаж, үр дүн зохих түвшинд гарч болох байдалд зохих талаар илэрхийлж, тайланг дэлгэрэнгүй авч хэлэлцэхээр заасан.

**3.9** Монголбанкаас Богд банкинд хийсэн иж бүрэн шалгалтын дагуу зохиож байгаа ажил, арга хэмжээ, зөрчлийн заалтын биелэлттэй Хорооны хурал дээр бичсэнээр танилцаж цаашид ажлаа эрчимжүүлэх үүрэг өгсөн. Ялангуяа зээлийн өрийн үлдэгдлийн хугацааны болон чанарын ангиллыг шуурхай хийх, зохих хууль журмын дагуу Монголбанкинд тайлагнах, тайлан, мэдээлэл, ажлын гүйцэтгэлийн хугацаанд Нь гаргаж байхын хамт шалгалтын материалд дурдсан ажлын доголдол, дутагдлыг таслан зогсоо арга хэмжээг төлөвлөгөөтэйгөөр авч хэрэгжүүлэх үүрэг өгсөн.

Монгол банкаас өргөн хүрээтэй, Богд банкны бүх ажил, газар, хэлтэс, нэгжийг хамарсан иж бүрэн шалгалт хийсэн материалаа нууцын зэрэглэлд оруулж Монгол банкны Ерөнхийлөгчийн тушаалаа нууцын дугаартай гаргасан нь шалгалтын ул мөрөөр зохиох ажил, авах арга хэмжээ,



нийт газар хэлтэс, орон нутаг, албадаас зохиох ажлыг хязгаартай болгож байгааг Аудитын хороо энэхүү тайландаа тэмдэглэж байна.

## ДӨРӨВ. НЭР ДЭВШҮҮЛЭХ, ҮНЭЛГЭЭ, УРАМШУУЛЛЫН ХОРООНЫ АЖИЛД

4.1. Хорооны хуралд 1 удаа оролцож, банкны гүйцэтгэх захирлын эхний хагас жилийн ажлын гүйцэтгэлийг дүгнэх тухай санал, ажлын дүнг хэлэлцэж, ажлын гүйцэтгэлийг "хангалттай" гэж дүгнэх саналыг дэмжсэн. Энэ нь Богд банкны эхний хагас жил, 3-р улирлын дүнг Аудитын хорооны хурлаар хэлэлцсэн болохоор ажлын дүнг тодорхой мэдэж байсан учраас дэмжиж санал өгсөн. Харин ЭУГ-ын дарга чөлөөлөгдсөн. Орны хүний талаар Гүйцэтгэх удирдлага судалгаа хийж байгаа гэдгээ танилцуулаад байна.

### ТАВ. ҮРДҮН, САНАЛ

5.1. Банкны үйл ажиллагаа, санхүү зээлийн бодлоготой холбогдсон ажилд зайлшгүй шаардлагатай асуудлаар ТУЗ, түүний хороод зохих үүрэг, шаардлагын дагуу ажилласан гэж хувьдаа дүгнэдэг. ТУЗ-аар шийдвэр гаррагүйгээс, эсвэл saatаж удаашруулснаас болж, банкны ажил үр дүнд сөрөг нөлөөлсөн зүйл байхгүй гэж харж байна. Гэвч цаашид ТУЗ, түүний хороодын ажлыг улам идэвхижүүлэх, гишүүд бүр хэлэлцэх асуудлаар тодорхой санал, шүүмж, судалгаа, тооцоотой жигд ажиллах нь чухал гэж үзнэ.

5.2. ТУЗ, түүний хороодын ажилд Монгол банкнаас өгөх чиглэл заалт, мэдээллийг нэмэгдүүлэх шаардлагатай гэж боддог. Монгол банкнаас хийсэн шалгалт, өгсөн үүрэг хамт олонд хүрдэг, ажил хэрэг болдог байх, шалгалтын материал өгөх үүргээ нууцлахгүй байхыг ч анхаараасай гэж боддогоо нуухгүй хэлье. Зарим үед Монгол банк ТУЗ-ийн гишүүдтэй биечлэн уулзаж, санал хүсэлтийг нь сонсох, тэргүүний ажиллагаатай ТУЗ-ийн арга барилыг нэвтрүүлэх, ТУЗ-ийн ажилд тодорхой заалт, заавар өгч байх, Монгол банкнаас тавьж буй зорилт шаардлагыг хэрэгжүүлэхэд авах арга хэмжээний талаар зааварлаж шаардаж байгаасай гэж хүсдэг.

5.3. Энэхүү тайлангийн 3.4-д бичсэн гадаадын хөрөнгө оруулалттай Эрнст энд Янг Монгол зэрэг аудитын компаниуд нь Монголын хуулийн этгээд атлаа өндөр үнэтэйгээр аудит хийдэг, аудитын дүгнэлт, материалаа англи хэлээр боловсруулж, монгол хэл дээр гаргаж өгөхийг хүсэхэд нэмэлт хөлс зардал шаарддаг нийтлэг, зохисгүй шаардлага тавьж байгааг өөрчлүүлэх арга хэмжээг Монгол банк санаачлан зохион байгуулахыг санал хүсэлт болгон тавьж байна.

5.4. Банкны ажлын хүрээ, хэмжээ өсч харилцагчдад түргэн шуурхай үйлчлэх шаардлага нэмэгдэж байгаа өнөөгийн нөхцөлд банкны өдөр тутмын ажил боловч гүйцэтгэх удирдлагын шийдвэр гаргах эрх хэмжээнээс /зээл, батлан даалт, зээлийн үндсэн өр, хүүгийн төлбөр г.м/ хэтэрсэн олон асуудал гарч, тэр бүхнийг яаралтайгаар ТУЗ, түүний хороодод танилцуулан шийдвэр гаргах явдал нэлээд төвөгтэй, багагүй чирэгдэлтэй, гүйцэтгэх удирдлагын ажилд ч хүндрэлтэй байгааг харгалзан хууль зөрчихгүйгээр эдгээр асуудлыг шийдэх, хөнгөвчлөх ямар арга зам, боломж байгаа талаар Монголбанкнаас зөвлөмж, аргачлал өгөх, шаардлагатай бол журам гаргах арга хэмжээ авахыг хүсэж байна.

Богд банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүн  
АХ, ЭУХ-дын дарга:  
2024.01.09

/Э.Бямбажав/